



## МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 1/79

Улаанбаатар хот

### Заавар шинэчлэн батлах тухай

Компанийн тухай хуулийн 83.1, “Монголын Хөрөнгийн Бирж” төрийн өмчит хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.9, 8.10.11 дэх заалтууд болон Санхүүгийн зохицуулах хорооны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 4.12 дугаар заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Монголын хөрөнгийн бирж” төрийн өмчит хувьцаат компанийн “Үнэт цаас гаргагчаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар”-ын шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталж 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
2. “Үнэт цаас гаргагчаас цахим хэлбэрээр мэдээлэл ирүүлэх заавар” шинэчлэн батлагдсантай холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2016 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 111 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.
3. Энэхүү зааврыг бүртгэлтэй компаниудад танилцуулах ажлыг зохион байгуулах, мэдээллийг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, гэрээнд нийцүүлэн, тэдгээрт заасан хугацаанд ирүүлж буй эсэхэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллахыг Хяналт зохицуулалтын газрын Хяналт шинжилгээний алба /М.Энхтуяа/-нд үүрэг болгосугай.
4. Мэдээллийг хүлээн авч, боловсруулах, түгээх, хадгалах, мэдээллийн сан бүрдүүлэхтэй холбоотой техник хангамжийн бэлэн байдлыг бий болгон, програм хөгжүүлэлтийг зохион байгуулж, тэдгээрийн аюулгүй, найдвартай байдлыг ханган ажиллахыг Үйл ажиллагааны газрын Мэдээлэл технологийн алба /С.Амарсанаа/-нд үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

000017

МХБ ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын ... дугаар сарын  
28-ний өдрийн 179 дугаар талбарын авсрагт



## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧААС ЦАХИМ ХЭЛБЭРЭЭР МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ ЗААВАР

/Шинэчилсэн найруулга/

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү зааврын зорилго нь “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК (цаашид “Бирж” гэх)-д бүртгэлтэй үнэт цаас гаргагч (цаашид “Компани” гэх) нь хууль журмын дагуу нийтэд зайлшгүй хүргэх болон үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх бусад мэдээллийг тогтоосон хугацаанд олон нийтэд ил тод, нээлттэй хүргэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх мэдээлэлтэй холбоотой нарийвчилсан заавар, зөвлөмжийг энэхүү заавраас тусад нь баталж болно.
- 1.3 Энэ заавар нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны холбогдох журам, Биржийн журам, заавар, гэрээ болон тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн баримт бичигт үндэслэнэ.
- 1.4 Энэхүү зааврыг хэрэгжүүлэхдээ хууль дээдлэх, хуулийн дагуу компанийн нууцад хамаарахаас бусад мэдээлэл нээлттэй, ил тод, бодитой, үнэн зөв, бүрэн гүйцэд, хоёрдмол утга агуулгагүй байх, мэдээллийг нийтэд хүргэх үйл ажиллагаа шуурхай байх зарчмыг баримтална.
- 1.5 Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн нарийн бичгийн дарга, эсхүл компанийн эрх бүхий этгээдээс томилсон үнэт цаас хариуцсан албан тушаалтан (эдгээрийг цаашид “ТУЗ-ийн нарийн бичгийн дарга” гэх) нь мэдээллийг энэхүү зааврын хавсралтад заасан маягт (цаашид “Маягт” гэх)-ын дагуу бөглөж цахим хэлбэрээр (интернэтийн холболтгүй тохиолдолд хэвлэмэл байдлаар) ирүүлнэ.
- 1.6 Энэхүү журмын хэрэгжилтэд дараах албан тушаалтан хяналт тавьж ажиллана. Үүнд:
- 1.6.1 Компаниас цахим хэлбэрээр ирүүлсэн мэдээллийг хянах, хавтаст материалд хадгалах, бүртгэл хөтлөх, боловсруулах, түүнийг нийтийн хүртээл болгох ажлыг Биржийн компани хариуцсан мэргэжилтэн (Цаашид “Биржийн мэргэжилтэн” гэх),
- 1.6.2 Мэдээллийн сан бүрдүүлэх, түүнийг хадгалах ба мэдээллийн сангийн болон мэдээлэл хүлээн авах, түгээх үйл ажиллагааны аюулгүй, найдвартай байдлыг Биржийн Мэдээлэл технологи хариуцсан алба, нэгж (цаашид “МТА” гэх) хариуцна.
- 1.7 Компанийн цахим хэлбэрээр ирүүлсэн мэдээ баримтыг компанийн албан ёсны баримт бичигтэй адилтган үзэх ба мэдээллийг Монгол хэл дээр бичгэн болон тоон хэлбэрээр үйлдэнэ. Шаардлагатай тохиолдолд, эсхүл сайн дурын үндсэн дээр мэдээллийг Англи хэл дээр үйлдэж болно.

ХОЁР. ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН МАЯГТЫН АНГИЛАЛ,

ТӨРӨЛ, ХУГАЦАА

2.1 Компаниудаас цахим хэлбэрээр ирүүлэх мэдээллийн маягт нь дараах үндсэн 5 ангилалд хуваагдана. Үүнд:

- 2.1.1 Ерөнхий мэдээлэл;
- 2.1.2 Санхүүгийн мэдээлэл;
- 2.1.3 Үйл ажиллагааны тайлан, мэдээлэл;
- 2.1.4 Хувьцаа эзэмшигчдийн болон ТУЗ-ийн хурлын мэдээлэл;
- 2.1.5 Хууль тогтоомжид тусгасан бусад мэдээлэл;

2.2 Ангилал тус бүрт хамаарах мэдээллийн нэр төрөл, тэдгээрийн маягтын дугаар, тайлагнах ерөнхий хугацааг дараах байдлаар тодорхойлно. Үүнд:

№	Мэдээллийн төрөл	Маягтын дугаар	Тайлагнах хугацаа
I	<b>ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ</b>		
1.1	Компанийн оноосон нэр, байгуулагдсан огноо, үндсэн захиргаа болон толгой компанийн оршин байх хаяг байршил, түүний өөрчлөлт	Маягт-1	Тухай бүр
1.2	Компанийн үйл ажиллагааны чиглэл, түүнд орсон өөрчлөлт, үйл ажиллагаа түр болон удаан хугацаагаар эсхүл бүхэлдээ зогссон		
1.3	Компанийн үнэт цаасны талаарх мэдээлэл		
1.4	Үндсэн болон шинэ бүтээгдэхүүнд зориулан тусгай зөвшөөрөл, патент, үйл ажиллагаа явуулах эрх, барааны тэмдэг эзэмших болон цуцлагдах болсон		
1.5	Компанийн ажиллагсад, тэдгээрийн 15 болон түүнээс дээш хувьд өөрчлөлт орсон		
1.6	Компани салбар төлөөлөгчийн газар байгуулах, татан буулгах болсон талаарх мэдээлэл		
1.7	Компанийн эрх бүхий албан тушаалтан, түүний өөрчлөлт	Маягт-2	Тухай бүр
1.8	Компанийн ТУЗ-ийн бүрэлдэхүүн, түүний өөрчлөлт	Маягт-3	Тухай бүр
1.9	Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, тэдгээрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн өөрчлөлтийн талаарх мэдээлэл болон тэдгээрийн бусад компанид эзэмшиж байгаа хувьцаанд гарсан өөрчлөлт	Маягт-4	Тухай бүр
II	<b>САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ</b>		
2.1	Аудитлагдсан жилийн эцсийн болон хагас жилийн санхүүгийн тайлан, тодруулга	Маягт-5	Жилээр, хагас жилээр

2.2	Компанийн хөрөнгө, өр төлбөр, хувьцаат капитал болон үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлэх гэрээ хэлцэл байгуулах			
2.3	Компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувьд нөлөөлөх бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай байгуулсан гэрээ хэлцлийг цуцлах, дуусгавар болгох	Маягт-6	Тухай бүр	
2.4	Компанийн борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш хувийг эзэлдэг үйл ажиллагаатай холбогдох аливаа тусгай зөвшөөрөл /лиценз/ эзэмших болсон, эсхүл түүнийг хүчингүй болгосон, барьцаалсан, аливаа хэлбэрээр бусдад шилжүүлсэн			
2.5	Компанийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнгийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийг худалдах, барьцаалах болон бусад хэлбэрээр бусдад шилжүүлэх, битүүмжлэх, тусгаарлах	Маягт-7	Тухай бүр	
III	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ</b>			
3.1	Жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайлан	Маягт-8	Жилээр, хагас жилээр	
3.2	Компанийн бизнесийн үйл ажиллагааны зарим хэсгийг охин, хараат компанид болон бусад этгээдэд шилжүүлэх, эсхүл хязгаарлах болсон	Маягт-9	Тухай бүр	
3.3	Компани үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлэх, хувьцааны ханшид нөлөөлөхүйц шинэ бүтээгдэхүүн зах зээлд танилцуулах	Маягт-10	Тухай бүр	
IV	<b>ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БОЛОН ТУЗ-ИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ</b>			
4.1	Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр, хурлын зар, хурлын мэдэгдэл	Маягт-11	Тухай бүр	
4.2	Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, бусад холбогдох баримт материал	Маягт-12	Тухай бүр	
4.3	Компанийн ТУЗ-өөс гаргасан үнэт цаасны үнэ ханшид нөлөөлөх аливаа шийдвэр	Маягт-13	Тухай бүр	
V	<b>ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАСАН БУСАД МЭДЭЭЛЭЛ</b>			
5.1	Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн талаарх мэдээлэл	Маягт-14	Тухай бүр	
5.2	Компани бусад компанийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдах, худалдан авах болсон	Маягт-15	Тухай бүр	
5.3	Шүүх ажиллагаатай холбоотой мэдээлэл	Компани төлбөрийн чадваргүй болох	Маягт-16	Тухай бүр
5.4		Компанийг татан буулгах тухай шийдвэр	Маягт-17	Тухай бүр
5.5		Компани шүүхэд нэхэмжлэгч, хариуцагчаар оролцох	Маягт-18	Тухай бүр
5.6		Хувьцааны хяналтын багц эзэмшигчид болон эрх бүхий албан тушаалтнуудын гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон.	Маягт-19	Тухай бүр

- 1.8 Зааврын 2.2-т тусгасан тайлагнах ерөнхий хугацааг дараах байдлаар ойлгоно. Үүнд:
- 1.8.1 Жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор;
  - 1.8.2 Хагас жилийн үйл ажиллагааны тайланг жил бүрийн 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор;
  - 1.8.3 Жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгыг дараа жилийн 02 дугаар сарын 10-ны дотор, харин аудитын дүгнэлт, тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 01-ний дотор;
  - 1.8.4 Хагас жилийн санхүүгийн тайланг дараа сарын 20-ны дотор;
  - 1.8.5 Тухай бүр нийтэд хүргэх болон ханшид нөлөөлөх бусад мэдээллүүдийг тухайн үйл явдал, өөрчлөлт болсноос хойш ажлын 1 өдрийн дотор.

### **Гурав. МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАХ, МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ХҮРГЭХ ЗААВАРЧИЛГАА**

- 3.1. Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь маягтын дагуу цахим мэдээллийн санд мэдээлэл оруулах, нийтэд хүргэх үүргийг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:
- 3.1.1. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь маягтын дагуу мэдээллийг оруулахдаа нэршлийн дагуу маягтаа сонгон ШИНЭЭР НЭМЭХ товч дээр дарж мэдээллээ оруулна. Мэдээллийг оруулахдаа талбар тус бүрт зохих мэдээллийг бөглөж, дууссан тохиолдолд ХАДГАЛАХ товчийг дарна.
  - 3.1.2. Хадгалсан мэдээллийг Биржийн мэргэжилтэн хянасны үндсэн дээр нийтэд мэдээлэх бөгөөд нийтлэгдсэн мэдээллийг засварлах тохиолдолд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь Биржийн мэргэжилтэнд хандан нийтлэх товчийг идэвхигүй болгоно. Мэдээллийг шинэчлэн засварлахдаа маягтаа сонгон ЗАСАХ товчийг дарж мэдээллийг өөрчлөн ХАДГАЛАХ товчийг дарна. Хадгалагдсан мэдээллийг биржийн мэргэжилтэн дахин хянаж НИЙТЛЭХ товчийг дарснаар засварласан мэдээлэл цахим хуудсанд албан ёсоор байршина.
  - 3.1.3. Маягтын дагуу ХАВСРАЛТ файл гэсэн сонголттой хэсгүүдэд тухайн мэдээлэлтэй холбогдох нотлох баримтыг pdf форматаар оруулна. Компанийн тогтоол, тушаал, шийдвэр болон эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан болон түүнтэй дүйцэх бусад нотлох баримтын эх хувийг сканердаж pdf форматаар оруулна.
  - 3.1.4. Зааврын 3.1.3-т заасны дагуу мэдээллийг хавсаргахдаа үг үсэг, тамга тэмдэг, түүнд тусгагдсан мэдээллийг бүрэн гүйцэд гаргацтай байдлаар хуулбарласан байх ба файлын багтаамж, хэмжээнд биржийн зүгээс хязгаар тогтоож болно.
- 3.2 Биржийн холбогдох нэгж, мэргэжилтэн компаниас ирүүлсэн мэдээллийг хүлээн авах, хянах, олон нийтэд хүргэх, хадгалах үйл ажиллагааг дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:
- 3.2.1 Биржийн мэргэжилтэн нь компаниас ирүүлсэн мэдээлэл, түүнд хавсаргасан материалыг хууль тогтоомж, журам зааварт нийцсэн эсэхийг, эх баримт бичигтэйгээ

тохирч байгаа эсэхийг нягтлан, хянах ба уг мэдээллийг олон нийтэд хүргэх боломжтой гэж үзсэн тохиолдолд НИЙТЛЭХ товчийг дарна.

3.2.2 Хэрэв компаниас ирүүлсэн мэдээлэл нь алдаатай, дутуу эсхүл тодруулах шаардлагатай гэж үзвэл Биржийн мэргэжилтэн нь уг асуудлыг компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргад мэдэгдэж зохих засварыг хийлгэнэ.

3.2.3 Биржийн мэргэжилтэн нь НИЙТЛЭХ товч дарахад уг мэдээлэл нь олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэгдэж, биржийн цахим хуудсаар үнэ төлбөргүй мэдээлэгдэнэ.

3.2.4 Компаниас цахим хэлбэрээр ирүүлсэн худал, алдаатай, агуулгын хувьд хоёрдмол утга санаа илэрхийлсэн мэдээлэл болон хянаагүй мэдээллийг нийтлэхийг хориглоно.

3.2.5 Үнэт цаас гаргагчийн зарим мэдээлэл (Биржийн үнэт цаасны бүртгэл, компанийн санхүүгийн тайлан тэнцэлтэй холбоотой болон биржид бүртгэлгүй этгээд нь хувьцаа худалдан авах зэрэг мэдээллүүд)-ийг Биржийн мэргэжилтэн цахим мэдээллийн санд оруулж болно.

3.2.6 Олон нийтэд хүргэх хэсэгт бүртгэгдсэн мэдээлэл нь компаниас тухайн маягтын дагуу шинэ мэдээлэл ирэх бүрт цахим мэдээллийн санд архивлагдаж хадгалагдана.

3.2.7 МТА нь цахим мэдээллийн санд бүртгэгдсэн компаниудын мэдээллийг компани тус бүрээр, мэдээллийн маягтын нэрээр, эсхүл он сараар хайх, үзэх, судалгаа хийх боломжтой байдлаар хадгална.

### **Дөрөв. ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН НУУЦЛАЛ**

4.1 Биржийн мэргэжилтэн болон Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар нь цахим мэдээллийн санд нэвтрэх тус тусын нууц үгтэй байна. Нууц үгний нууцлалыг тухайн эзэмшигч хариуцах ба түүнийг бусдад шилжүүлэх, ашиглуулахыг хориглоно. Биржийн холбогдох мэргэжилтэнд шалтгаан бүхий хүсэлт гаргасны үндсэн дээр нууц үгийг өөрчилж болно.

4.2. Цахим мэдээллийн санд оруулсан бүх мэдээлэл нь олон нийтэд нийтлэгдэхээс өмнө нууцлалын зэрэглэлтэй байна. Хууль журмын дагуу хугацаа тогтоосноос бусад тохиолдолд компани нь тус мэдээллийг олон нийтэд хүргэх хугацааг тодорхой заасан байна. Олон нийтэд хүргэх хугацааг тодорхой заагаагүйгээс үүдэх хариуцлагыг бирж хүлээхгүй.

4.3. Биржийн мэргэжилтэн нь цахим мэдээллийн санд ирүүлсэн мэдээллийг хууль, тогтоомжийн хүрээнд нийтийн эрх ашигт нийцүүлэн хөрөнгийн зах зээл дэх мэдээллийн ил тод, үр дүнтэй байдлыг хангах, компанийн сайн засаглалыг бүрдүүлэх, судалгаа хийх зорилгоор ашиглаж болно.

## Тав. ХАРИУЦЛАГА

- 5.1. Үнэт цаас гаргагч компаниас цахим хэлбэрээр Биржид ирүүлсэн мэдээллийн үнэн зөвийг болон мэдээллийг ирүүлэхдээ энэхүү зааврын 1.4-т заасан зарчмыг мөрдөөгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг Компани, түүний холбогдох албан тушаалтан бүрэн хариуцна.
- 5.2. Компаниас ирүүлсэн мэдээллийг Биржийн цахим хуудсанд байршуулахдаа энэхүү зааврын 3.2.1-т заасан хяналтыг хэрэгжүүлээгүй, зааврын 1.6.2-т заасан мэдээлэл түгээлт ба цахим мэдээллийн сангийн хадгалалтын аюулгүй, найдвартай байдлыг хангахтай холбоотой үүргээ хэрэгжүүлээгүйгээс үүссэн үр дагаврыг Биржийн холбогдох нэгж, албан тушаалтан хариуцах бөгөөд хууль тогтоомж, журам, гэрээний дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 5.2. Компани нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хорооны журам, Биржийн журам, зааврыг зөрчсөн нь захиргааны хариуцлага ногдуулахааргүй бол Бирж нь уг асуудалд Бүртгэлийн журам ба гэрээний дагуу хариуцлагын арга хэмжээ ногдуулж болно.
- 5.3. Бирж нь зөрчил гаргасан этгээд зөрчлийг тогтоосон хугацаанд арилгаагүй, арилгахаас татгалзсан тохиолдолд энэ тухай Хороонд мэдэгдэх ба зөрчил гаргасан этгээдэд хариуцлага хүлээлгэх санал хүргүүлж болно.

## МАЯГТЫН ЖАГСААЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Маягт 1. Компанийн ерөнхий мэдээлэл

Маягт 2. Компанийн эрх бүхий албан тушаалтан

Маягт 3. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт

Маягт 4. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

## II. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Маягт 5. Санхүүгийн тайлан, тодруулга

Маягт 6. Хөрөнгийн өөрчлөлттэй холбоотой гэрээ хэлцэл

Маягт 7. Компанийн хөрөнгийн үнийн дүнгийн 10 болон түүнээс дээш хувьтай тэнцэх хөрөнгийн өөрчлөлт

## III. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

Маягт 8. Жилийн болон хагас жилийн үйл ажиллагааны тайлан

Маягт 9. Үйл ажиллагааны өөрчлөлт, шилжилт

Маягт 10. Үйл ажиллагаандаа шинэ техник, технологи нэвтрүүлсэн байдал

## IV. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БОЛОН ТУЗ-ИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Маягт 11. Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл

Маягт 12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр

Маягт 13. Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр

## V. ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАСАН БУСАД МЭДЭЭЛЭЛ

Маягт 14. Сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцэл

Маягт 15. Хувьцаа худалдан авах санал

Маягт 16. Төлбөрийн чадваргүй болсон тухай

Маягт 17. Таган буугдсан тухай

Маягт 18. Шүүхэд шалгагдаж буй байдал

Маягт 19. Шүүхээр гэм буруутай нь тогтоогдсон тухай



# I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

## МАЯГТ №-1. КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1	Компанийн нэр				
2	Байршил хаяг				
3	Байгуулагдсан огноо		..... он		
4	МХБ –д бүртгүүлсэн огноо		..... он ..... сар ..... өдөр		
5	Код	Тоон	.....		
		Үсгэн	.....		
6	Улсын бүртгэлийн дугаар .....		Регистрийн дугаар : .....		
7	Хувьцааны тоо ширхэг	Төрөл	Энгийн	Төрийн мэдэлд	Давуу эрхийн
		Зарласан	..... ширхэг	..... ширхэг	.....
		Гаргасан	..... ширхэг	..... ширхэг	.....
8	Нэгж хувьцааны нэрлэсэн үнэ		Анхны үнэ: ..... /төг/		Одоогийн үнэ: ..... /төг/
9	Хувьцаат капиталын дүн		Анхны дүн: ..... /төг/		Одоогийн дүн: ..... /төг/
10	Компанийн дүрэм	Сүүлчийн байдлаар	Компанийн дүрмийн хуулбар <i>Хавсралт</i>		
		ХЭХ шийдвэрийн огноо, дугаар	..... он ..... сар ..... өдөр		№.....
11	Үйл ажиллагааны чиглэл	Үндсэн	1.		
			2. <i>Нэмэгдэх</i>		
		Туслах	1.		
			2. <i>Нэмэгдэх</i>		
12	Үйл ажиллагаа явагдаж байгаа байдал		<input type="checkbox"/> Хэвийн		
			<input type="checkbox"/> Түр хугацаагаар зогссон		
			<input type="checkbox"/> Удаан хугацаагаар зогссон		
			<input type="checkbox"/> Бүхэлдээ зогссон		
13	Эзэмшиж буй тусгай зөвшөөрөл, патент, барааны тэмдэг	Зөвшөөрлийн утга	Авсан огноо	Олгосон байгууллага	Хугацаа
		1.	..... он		
		2.	..... он		
		3. <i>Нэмэгдэх</i>	..... он		
		Зөвшөөрлийн утга	Цуцалсан огноо:	Цуцалсан байгууллага	Хугацаа
		1.	..... он		
		2.	..... он		
		4. <i>Нэмэгдэх</i>			
		<i>Шийдвэр</i> <i>Хавсралт</i>			
14	Толгой, Охин, Хараат, компанийн тухай мэдээлэл		<input type="checkbox"/> Толгой компани		
			<input type="checkbox"/> Охин компани		
			<input type="checkbox"/> Хараат компани		
			<input type="checkbox"/> Байхгүй		
		Нэр:..... Хаяг:..... Үйл ажиллагааны чиглэл:.....			

15	Компанийн салбар, төлөөлөгчийн газар	<input type="checkbox"/> Тийм		Салбар /төлөөлөгч/-ын газрын нэр:.....	
		<input type="checkbox"/> Үгүй		Хаяг:.....	
		Шийдвэр		<i>Хавсралт</i>	
16	Ажилчдын шилжилт, хөдөлгөөн	Нийт ажилтны тоо	<input type="checkbox"/> Чөлөөлсөн	Тоо..... Хувь.....	Шийдвэрлэсэн огноо
			<input type="checkbox"/> Шилжсэн		
			<input type="checkbox"/> Шинээр ажилд орсон		
			<input type="checkbox"/> Өөрчлөлтгүй		

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

МАЯГТ №-2. КОМПАНИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцаа эзэмшдэг бол хувь ХЭМЖЭЭ
1	.....	.....	.....%
2			
	<i>Нэмэгдэх</i>		

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

МАЯГТ №-3. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮНД ОРСОН ӨӨРЧЛӨЛТ

Д/д	ТУЗ-ийн гишүүдийн мэдээлэл				
	Овог	Нэр	Регистрийн дугаар	Хувьцаа эзэмшдэг бол хувь хэмжээ	ТУЗ-ийн хараат/хараат бус гишүүн
1.				...%	
2.				...%	
3.				...%	
4.				...%	
5.				...%	
6.				...%	
7.				...%	
8.				...%	
9.	<i>Нэмэгдэх</i>			...%	

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

МАЯГТ №-4. НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Д/д	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч			Тус компанийн хувьцааг эзэмшиж буй байдал		Бусад компанийн хувьцааг эзэмшиж буй байдал		
	Овог	Нэр	Ажлын газар, албан тушаал	Хувьцааны тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь	Компанийн нэр	Хувьцааны тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь
1				..... ш	..... %		..... ш	..... %
2								
	<u>Нэмэх</u>							

Д/д	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч		Түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд			Тус компанид эзэмшиж буй хувьцаа	
	Овог	Нэр	Овог	Нэр	Холбоо хамаарал	Хувьцааны тоо ширхэг	Нийт хувьцаанд эзлэх хувь
1						..... ш	..... %
			<u>Нэмэх</u>				
2							
	<u>Нэмэх</u>						

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

## 2. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

### МАЯГТ №-5. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1	..... улирлын санхүүгийн тайлан		/төгрөгөөр/	
2	Санхүүгийн тайлан	Эхний үлдэгдэл ... он .....сар.... өдөр	Эцсийн үлдэгдэл ... он .....сар.... өдөр	
3	Санхүүгийн үзүүлэлтүүд		Санхүүгийн тайлангийн хуулбар  <i>Хавсралт</i>	
	Нийт хөрөнгө			
	Өр төлбөрийн нийт дүн			
	Эзэмшигчдийн өмчийн дүн			
	Нийт хувьцааны тоо ширхэг		.....ширхэг	.....ширхэг
4	Орлого үр дүнгийн тайлангийн үзүүлэлт			
	Нийт борлуулалтын орлого			
	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг			
	Нийт ашиг			
	Цэвэр ашиг			
	Ногдол ашиг	Энгийн Давуу эрхийн		
	Нэгж хувьцааны дансны үнэ		Эзэмшигчдийн өмч / хувьцааны тоо ширхэг	Эзэмшигчдийн өмч / хувьцааны тоо ширхэг
	Хувьцааны тухайн өдрийн хаалтын ханш		..... төг	..... төг
5	Санхүүгийн харьцаанууд	1. Нийт хөрөнгийн өгөөж (ROA)	Цэвэр ашиг /нийт хөрөнгө	Цэвэр ашиг /нийт хөрөнгө
		2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өгөөж (ROE)	Цэвэр ашиг / эзэмшигчдийн өмч	Цэвэр ашиг / эзэмшигчдийн өмч
		3. Нийт хөрөнгийн эргэц (ROTA)	Нийт орлого / нийт хөрөнгө	Нийт орлого / нийт хөрөнгө
		4. Нэгж хувьцааны өгөөж (EPS)	(Цэвэр ашиг – давуу эрхийн хувьцааны Ног.А) / гаргасан энгийн хувьцааны тоо	(Цэвэр ашиг – давуу эрхийн хувьцааны Ног.А) / гаргасан энгийн хувьцааны тоо
		5. Үнэ ашгийн харьцаа (P/E Ratio)	Хаалтын ханш / нэгж хувьцааны өгөөж	Хаалтын ханш / нэгж хувьцааны өгөөж
6	Аудит хийсэн байгууллагын нэр			
7	Аудитын дүгнэлт хийгдсэн огноо		..... он ..... сар ..... өдөр	

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

МАЯГТ №-6. ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ГЭРЭЭ, ХЭЛЦЭЛ

1	Гэрээ хэлцлийн утга	.....			
2	Гэрээ хэлцлийн төрөл	<input type="checkbox"/> Бэлтгэн нийлүүлэгч			
		<input type="checkbox"/> Худалдан авагчтай			
		<input type="checkbox"/> Бусад.....			
3	Хэлцэл баталсан /сонголттой Гүйцэтгэх удирдлага, ТУЗ эсхүл ХЭХ -ийн шийдвэр/	Шийдвэрийн дугаар	№	Шийдвэрийн хуулбар <u>Хавсралт</u>	
		Хурлын ирц	Нийт	Тоо	Хувь
			Зөвшөөрсөн	ш	%
			Татгалзсан	ш	%
		Түтгэлзсэн	ш	%	
4	Хэлцэл	Үнийн дүн			
		Хийхээс өмнөх сүүлийн балансын нийт активын дүн		..... төгрөг	
		Үнийн дүнгийн нийт активт эзлэх хувь		..... %	
		Хийхээс өмнөх сүүлийн балансын нийт борлуулалтын орлогын дүн		..... төгрөг	
		Үнийн дүнгийн борлуулалтын орлогод эзлэх хувь		..... %	
5	Гэрээ	<u>Хавсралт</u>			
6	Гэрээний нөгөө тал				
7	Нөхцөл болзол				
8	Хугацаа	Эхлэх	..... он ..... сар ..... өдөр		
		Дуусах	..... он ..... сар ..... өдөр		
9	Гэрээ	<input type="checkbox"/> Байгуулсан			
		<input type="checkbox"/> Цуцалсан			
10	Борлуулалтын орлогын 20 ба түүнээс дээш үнийн дүнтэй тусгай зөвшөөрөл	<input type="checkbox"/> Эзэмших болсон		Үнийн дүн:..... Хувь:.....%	
		<input type="checkbox"/> Хүчингүй болсон			
		<input type="checkbox"/> Барьцаалсан			
		<input type="checkbox"/> Бусдад шилжүүлсэн			
11	Бусад				

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

МАЯГТ №-7. КОМПАНИЙН ХӨРӨНГИЙН ҮНИЙН ДҮНГИЙН 10-ААС ДЭЭШ %-ТАЙ ТЭНЦЭХ ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТ

1	Компанийн хөрөнгийн дүн	..... төгрөг	
2	Хөрөнгийн өөрчлөлт /%-иар/	..... %	
3	Хөрөнгийн өөрчлөлтийн төрөл	<input type="checkbox"/> Худалдсан <input type="checkbox"/> Барьцаалсан <input type="checkbox"/> Бусдад шилжүүлсэн <input type="checkbox"/> Битүүмжилсэн, <input type="checkbox"/> Тусгаарласан хөрөнгийн жагсаалт	
4	Өөрчлөлт орсон хөрөнгө	..... хөрөнгийн гэрчилгээний дугаар	
		Нэр	.....
		Байршил	.....
		Өөрчлөлт орсон үл хөдлөх хөрөнгийн дүн	.... төгрөг
		Компанийн үл хөдлөх хөрөнгийн дүн	.... төгрөг
		Компанийн үл хөдлөх хөрөнгийн үнийн дүнд эзлэх хувь	.....%
		Дуусах хугацаа	...он ...сар ... өдөр
5	Шийдвэр	Гаргасан этгээд	
		Огноо	...он ...сар ... өдөр
6	Бусад		

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:



### 3. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ

МАЯГТ №-8. ЖИЛИЙН /ХАГАС ЖИЛИЙН/ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

1. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл

2. Удирдлагын талаарх мэдээлэл

3. Санхүүгийн байдлын талаарх мэдээлэл

4. Хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл

5. Ногдол ашгийн талаарх мэдээлэл

6. Бусад шаардлагатай мэдээлэл

**Санамж:** Жилийн үйл ажиллагааны тайланд СЗХ-ны “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 2.3-т заасан мэдээллийг дээрх дэд сэдвийн хүрээнд бүрэн оруулна. Харин хагас жилийн үйл ажиллагааны тайланд тус журмын 2.3.1.1-2.3.1.4, 2.3.2.1, 2.3.2.2, 2.3.3.1, 2.3.3.3, 2.3.3.5, 2.3.3.5, 2.3.4.1-2.3.4.3, 2.3.5.2-т заасан мэдээллүүдийг тусгах бөгөөд хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэд шаардлагатай гэж үзсэн эдгээрээс бусад мэдээллийг тусгаж болно.

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

МАЯГТ №-9. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ӨӨРЧЛӨЛТ, ШИЛЖИЛТ

Шилжүүлэгч тал		Шилжүүлэн авсан тал		
Компанийн нэр	.....	Компанийн нэр	.....	
		Үйл ажиллагааны чиглэл	.....	
Үйл ажиллагаагаа	<input type="checkbox"/> Шилжүүлсэн	Холбоо хамаарал	<input type="checkbox"/> Толгой компани	
	<input type="checkbox"/> Хязгаарласан		<input type="checkbox"/> Охин компани, <input type="checkbox"/> Хараат компани, <input type="checkbox"/> Бусад этгээд .....	
Өөрчлөлт орсон үйл ажиллагааны чиглэл		.....		
Шийдвэрлэсэн этгээд	.....	Огноо/№	.....	Шийдвэр <u>Хавсралт</u>

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо

МАЯГТ №-10. ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

Д/д	<input type="checkbox"/> Шинэ техник <input type="checkbox"/> Шинэ технологи <input type="checkbox"/> Шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ	Тайлбар /нэр, төрөл/	Нэвтрүүлсэн огноо	Танилцуулга <u>Хавсралт</u>
1	.....	.....	... он... сар...өдөр	
2	.....	.....		
	<u>Нэмэгдэх</u>			
Шийдвэр гаргасан этгээд	.....	Огноо	.....	Шийдвэр <u>Хавсралт</u>

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

#### 4.ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БОЛОН ТУЗ-ИЙН ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

МАЯГТ №-11. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

1.	Хувь нийлүүлэгчдийн хурал	<input type="checkbox"/> Ээлжит	<input type="checkbox"/> Ээлжит бус
2.	ХНХ хуралдах хугацаа	..... он ..... сар ..... өдөр ..... цаг	
3.	Бүртгэх өдөр	..... он ..... сар ..... өдөр	
4.	Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах өдөр	..... он ..... сар ..... өдөр	
5.	Зарлуулсан эх сурвалж /он, сар, өдөр, дугаар/	1. .... /.....он, .....сар, ..... өдөр,..... дугаар/ 2. .... /.....он, .....сар, ..... өдөр,..... дугаар/ 3. .... /.....он, .....сар, ..... өдөр,..... дугаар/	
6.	Хуралдах газрын хаяг		
7.	Хурлаар хэлэлцэх асуудлууд	1. 2. 3. 4. <p style="text-align: right;"><u>Нэмэгдэх</u></p>	
8.	Шийдвэр	Гаргасан этгээд	
		Огноо, дугаар	..... он ..... сар ..... өдөр №.....
9.	Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн		
10.	Холбоо барих утас		

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

МАЯГТ №-12. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

1.Хувьцаа эзэмшигчдийн хурал	<input type="checkbox"/> Ээлжит	<input type="checkbox"/> Ээлжит бус
Хуралдсан огноо	..... он ..... сар ..... өдөр ..... цаг	
Хуралдсан газар		
Хурлын ирц	..... %	
2.ХЭХ –ын шийдвэр	Санал	Хувь
1.  <i>Хэлэлцсэн асуудал</i>	Зөвшөөрсөн	....%
	Татгалзсан	....%
	Түдгэлзсэн	....%
2.  <i>Хэлэлцсэн асуудал</i>	Зөвшөөрсөн	....%
	Татгалзсан	....%
	Түдгэлзсэн	....%
3.  <i>Нэмэгдэх</i>	Зөвшөөрсөн	....%
	Татгалзсан	....%
	Түдгэлзсэн	....%
3 Хурлын шийдвэр	Хурлын шийдвэрийн хуулбарыг хавсаргана <i>Хавсралт</i>	
4.Хурлын протокол	Хурлын протоколын хуулбарыг хавсаргана. <i>Хавсралт</i>	
5.Бусад асуудал		

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

МАЯГТ №-13. ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР

1.ТУЗ-ийн хурал		
Хуралдсан огноо	..... он ..... сар ..... өдөр ..... цаг	
Хуралдсан газар		
Хурлын ирц	..... %	
2.ТУЗ -ийн шийдвэр		
	Санал	Хувь
1.  <i>Хэлэлцсэн асуудал</i>	Зөвшөөрсөн	...%
	Татгалзсан	...%
	Түдгэлзсэн	...%
2.  <i>Хэлэлцсэн асуудал</i>	Зөвшөөрсөн	...%
	Татгалзсан	...%
	Түдгэлзсэн	...%
3.  <i>Нэмэгдэх</i>	Зөвшөөрсөн	...%
	Татгалзсан	...%
	Түдгэлзсэн	...%
3.Хурлын шийдвэр	Хурлын шийдвэрийн хуулбарыг хавсаргана. <i>Хавсралт</i>	
4.Хурлын протокол	Хурлын протоколын хуулбарыг хавсаргана. <i>Хавсралт</i>	
5.Бусад асуудал		

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

**5. ХУУЛЬ ТОГТООМЖИД ТУСГАСАН БУСАД МЭДЭЭЛЭЛ**

МАЯГТ №-14. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ БОЛОН ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЭЛ

1	Хэлцлийн төрөл		<input type="checkbox"/> Сонирхлын зөрчилтэй хэлцэл <input type="checkbox"/> Их хэмжээний хэлцэл <input type="checkbox"/> Их хэмжээний бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл		
2	Хэлцлийн утга		.....		
3	Хэлцлийг баталсан ХЭХ/ТУЗ/	Шийдвэрийн дугаар	№ ....	Шийдвэрийн хуулбар <u>Хавсралт</u>	
		Хурлын ирц	Нийт	Тоо : . ....	Хувь: .....
			Зөвшөөрсөн	.....ширхэг	.....%
			Татгалзсан	.....ширхэг	.....%
		Түдгэлзсэн	.....ширхэг	.....%	
Огноо	..... он ..... сар ..... өдөр				
4	Хэлцэл	Үнийн дүн		..... төгрөг	
		Хийхээс өмнөх сүүлийн балансын нийт активийн дүн		..... төгрөг	
		Үнийн дүнгийн нийт активт эзлэх хувь		..... %	
5	Гэрээний хуулбар		<u>Хавсралт</u>		
6	Гэрээний нөгөө тал		.....		
7	Нөхцөл болзол		.....		
8	Хугацаа	Эхлэх	..... он ..... сар ..... өдөр		
		Дуусах	..... он ..... сар ..... өдөр		
9	Гэрээ хийгдсэн огноо		..... он ..... сар ..... өдөр		
10	Бусад				

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

МАЯГТ №-15. ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ САНАЛ

№	<input type="checkbox"/> Сайн дурын үндсэн дээр худалдан авах санал <input type="checkbox"/> Үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр худалдан авах санал	<input type="checkbox"/> Хуулийн этгээд <input type="checkbox"/> Хувь хүн	
	Худалдан авагч этгээдийн мэдээлэл		
1	Худалдан авах санал гаргаж буй хуулийн этгээдийн нэр: Хаяг: Утас: Улсын бүртгэлийн дугаар: Регистрийн дугаар:	Ургийн овог: Эцэг эхийн нэр: Өөрийн нэр: Оршин суугаа хаяг: Регистрийн дугаар:	
2	Хувьцаа худалдан авах саналыг гаргаж буй хугацаа	Эхлэх огноо...	Дуусах огноо...
3	Худалдан авахыг хүссэн нийт хувьцааны тоо, хувь	... ш	....%
4	Худалдах саналыг хүлээн авах өдөр		
5	Хувьцааг худалдан авах төлбөрийг гүйцэтгэх өдөр		
6	Тухайн компанид эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь	... ш	...%
7	Худалдан авах санал гаргагч болон холбогдох этгээд өөр компанийн хувьцааг эзэмшиж буй талаар мэдээлэл	Сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргагчид заавал бөглөнө.	
8	Санхүүгийн чадвартайг нотолсон баримт /Хавсралт оруулах/	Сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргагчид заавал бөглөнө.	
9	Худалдан авах санал гаргах болсон шалтгаан, зорилго		
10	Худалдан авахыг хүссэн хувьцааны тоо, хувь		
12	Нэгж хувьцааг худалдан авах үнийн санал		
13	Санал гаргагчийн харилцагч ҮЦК, утасны дугаар		
14	Худалдан авах санал гаргагчийн худалдах саналыг хүлээн авах шуудангийн хаяг		

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

ШҮҮХ АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

МАЯГТ №-16. ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ БОЛСОН ТУХАЙ

№	Төлбөрийн чадваргүй болсон компани	Компанийн нэр	Өөрийн хөрөнгийн дүн	Заасан хугацаанд биелэгдээгүй төлбөр	Өөрийн хөрөнгөнд эзлэх хувь
1	<input type="checkbox"/> Компани өөрөө	..... ХК	..... төгрөг	..... төгрөг	... %
	<input type="checkbox"/> Толгой компани				
	<input type="checkbox"/> Охин компани				
	<input type="checkbox"/> Хараат компани				
2	Шийдвэр гаргасан этгээдийн нэр	.....		Шийдвэр гаргасан огноо	.....
3	Шийдвэрийн хуулбар	<i>Хавсралт</i>			

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

МАЯГТ №-17. ТАТАН БУУГДСАН ТУХАЙ

1	Татан буулгах шийдвэр гаргасан этгээдийн нэр	.....		
2	Татан буулгасан үндэслэл	.....		
3	Шийдвэр гаргасан огноо/№	.....	Шийдвэр	<i>Хавсралт</i>
4	Татан буулгах комисс	.....	Холбогдох хаяг, утасны дугаар	.....

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:



МАЯГТ №-18. ШҮҮХЭД ШАЛГАГДАЖ БҮЙ БАЙДАЛ

№	Компанийн нэр	<input type="checkbox"/> Нэхэмжлэгч <input type="checkbox"/> Хариуцагч	Шалтгаан /тайлбар/	Огноо		
1	.....	.....	.....	.....		
2						
	<u>Нэмэгдэх</u>					
	Шийдвэр гаргасан этгээд	.....	Огноо/№	.....	Шийдвэр	<u>Хавсралт</u>

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо:

МАЯГТ №-19. ШҮҮХЭЭР ГЭМ БУРУУТАЙ НЬ ТОГТООГДСОН ТУХАЙ

	Овог нэр	Албан тушаал	Тухайн компанид эзэмшиж буй хувьцаа		Шүүхийн шийдвэр
1	.....	.....	... ш	...%	<u>Хавсралт</u>
2					
	<u>Нэмэгдэх</u>				

Мэдээлэл оруулсан огноо:

Шинэчлэгдсэн огноо: